



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэг
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа
Утас: 7036-3040
Цахим хаяг: ch.enkh@yahoo.com

Аудитын менежер Б.Батмөнх
Утас: 7036-3047
Цахим хаяг:
ba_batmunkh@yahoo.com

Аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 7036-2442
Цахим хаяг:
Sbaterdene991@yahoo.com

ТАБ-ын хаяг: УАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн Аудитын газар
Байршил: АЗДТГ-ын байрны
өргөтгөлд
Цахим хуудас:
www.Selenge@audit.gov.mn

2016 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Менежментийн захидал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 70-36-30-40, Факс: (976) 70-36-30-40
E-mail: Selenge@audit.gov.mn

2016.02.25 № СЭН/2016/05-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ДАРГА Ө.СУВДАА ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газраас аудит хийв.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь тус байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл:

Сэлэнгэ аймгийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Аудитаар илэрсэн 21,626.8 мянган төгрөгийн материаллаг алдаа, зөрчил нь бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс бага байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА